

158



Б Н М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 05.

№ 337.

Улаанбаатар
хот

"Дугуй" компани байгуулах
тухай.

БНМАУ-ын аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн
Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

Нэг. Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны
116 дугаар тогтоолоор байгуулагдсан "Дугуй" лүүсийг татан
буулгаж "Дугуй" компани /Улсын үйлдвэрийн газар/ болгон
өөрчлөн зохион байгуулсугай.

Хоёр. "Дугуй" компаны дүрмийг хавсралт ёсоор батал-
сугай.

Гурав. Энэ тогтоол гарч байгаатай холбогдуулан Улаан-
баатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 4 дү-
гээр сарын 19-ний өдрийн 116 дугаар тогтоолыг хүчингүй болсонд
тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА,
ЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

JSE

Л.ЭНЭБИШ

[Signature]

Ц.БОЛДСАЙХАН



130

Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны 1991 оны 337 тогтоолоор батлав.

"ДУГУЙ" КОМПАНИ /УУГ/-Ы ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Компани нэр "Дугуй" компани /УУГ/

2. Сршин байх газар, хаяг нь Улаанбаатар хотын Найрамдалын дүүргийн ОСГ-ны 4-р хорооны нутаг дэвсгэрт, Барилгын цэргийг удирдах ерөнхий газрын хойт дэнж дээр байрлана.

3. Тус компани нь дараахь ажил үйлчилгээ эрхлэнэ.

а. Гадаадтай хамтарч хөрөнгө оруулан гадаадын техник, технологийг нэвтрүүлж, унадаг дугуй болон тэрэг, тэргэнцэр, дугуйт барааны эд ангийг импортоор авч угсарч, дотоод гадаад зах зээлд борлуулах, тэдгээрийн засварын ажил

б. Бага оворын ачаа тээш тээвэрлэх асуудлыг ачааны дугуйгаар орлуулах асуудал

в. Унадаг дугуины төлбөртэй зөвшөөрөл ажиллуулах асуудал

г. Үйлдвэрлэлтэй холбогдол бүхий аливаа зүйлийг экспортлох, импортлох, валютыг тэнцвэртэй байлгахын тулд гадаад улсуудтай худалдаа хийх, бусад аж ахуйн нэгжүүдэд зуучлах

д. Ажиллагсадын харэгцээг үндэслэн дэлгүүр, гуанз, бусад үйлчилгээний ажлыг эрхлэх гэх мэт бусад асуудал.

4. "Дугуй" компани /УУГ/-ын үйл ажиллагааг хангах үүднээс 600,0 мянган төгрөгийн үйлдвэрийн барилга, 75,6 мянган төгрөгийн барилгын урсгал засварын ажил, 35,0 мянган төгрөгийн халаалтын зуух, 4,9 мянган төгрөгийн эд аж ахуйн зүйл, 495,0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө зэрэг бүгд 1210,5 мянган төгрөгийн дүрмийн сангаа Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны зээлийн хөрөнгөөр байгуулж байна. Тус компани нь дүрмийн сангаа бүрдүүлэхэд авсан зээлийг бүрэн төлж дуустал төрийн өмчинд тулгуурласан компани байна.

5. Дүрмийн санг бүрдүүлэхэд оролцсон гишүүн нь Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа гэсэн ганц гишүүнтэй компани мөн.

6. "Дугуй" /УҮГ/ нь 1210,5 мянган төгрөгийн дүрмийн сантай байна.

7. Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны "Дугуй" компани нь улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж гэрчилгээ авснаар хуулийн этгээдийн эрх эдэлж үүрэг хүлээнэ.

8. "Дугуй" компани нь үйл ажиллагаандаа БНМАУ-ын аж ахуйн нэгжийн тухай хууль, энэхүү дүрмийн заалтыг удирдлага болгон ажиллана.

ХОЁР. Удирдлага зохион байгуулалт

9. "Дугуй" компаны эрх барих дээд байгууллага нь Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргаа юм.

10. "Дугуй" компаныг ерөнхий захирал удирдана. Ерөнхий захирал компанийг төлөөлөх ба ерөнхий захирлаас бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр бусад хүн төлөөлж болно. Ерөнхий захирлыг Хотын АХ-ын гүйцэтгэх захиргаа томилоно.

11. Ерөнхий захирал нь гишүүдийн бүртгэл, хөрөнгийн тооцоохийх, тайлан, тэнцлийг гарган компанийг өдөр тутмын удирдлагаар хангана. Ажлаа хотын АХ-ын гүйцэтгэх захиргаанд тайлагнана.

12. Ерөнхий захирал компаныг төлөөлж дор дурдсан эрх эдэлнэ.

а. Компани нэрийн өмнөөс бусад байгууллага иргэнтэй шууд харилцах, хөдөлмөр, иргэний болон бусад гэрээ байгуулах, хэлцэл хийх

б. Компаны эд хөрөнгийг захиран зарцуулах

в. Компаны албан тушаалтан салбар нэгжүүдийн удирдлагыг томилох, чөлөөлөх

г. Үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох

13. Ерөнхий захирал хууль тогтоомжинд нийцүүлж тушаал заавар гаргана. Түүнийг компаны үйл ажиллагааны хүрээнд мөрдөнө.

ГҮРЭВ. "Дугуй" компаныг /УҮГ/ өөрчлөн байгуулах, татан буулгах

14. "Дугуй" /УҮГ/ компаныг дүрмийн санг бүрдүүлсэн зээлийг төлж дууссаны дараа өөрчлөн байгуулж болно. Өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хотын АХ-ын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.

15. Эцсийн тооцоог хуульд заасны дагуу хийнэ. "Дугуй" компани нь татан буугдсан тохиолдолд улсын бүртгэлээс хасуулна.